



Аудитын код: САГ-2018/112/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас 261740 Цахим хаяг tserendorj.d@audit.gov.mn

Гэрээгээр ажил гүйцэтгэсэн:

Бодьтусгал-аудит ХХК –ийн захирал З.Мягмарсүрэн
Утас: 11305165 Цахим хаяг: zmiiga999@gmail.com

Аудитор Г.Юмчмаа
Утас: 99908730 Цахим хаяг: g.yumchmaa1222@yahoo.com

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	2
2.1	Оршил	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	2
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	3
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	4
2.5	Дотоод хяналт	4
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	5
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	5
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	6
2.9.1	Нийгмийн даатгалын шимтгэлийн талаар	4
2.9.2	Дотоод хяналтын талаар	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	7
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал.....	8
3.1	Нийгмийн даатгалын шимтгэлийн талаар.....	9
3.2	Дотоод хяналтын талаар	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	11
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.5	Төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6	Улаанбаатарын их сургуулийн менежментийн захидлын хариу.....	20

1. Аудитын гэрчилгээ

УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.БАЙГАЛСАЙХАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатарын их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Улаанбаатарын их сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Тус сургуулийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.



Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц. НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Улаанбаатарын их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Улаанбаатарын их сургуулийн захирал С.Байгалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын тооцоог хууль, тогтоомжийн дагуу тооцоолж бүртгэх, нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, зохион байгуулалт дээр алдаатай байгаа зүйлсийг илрүүлж тус тус зөвлөмжинд тусгалаа.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага


Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатарын их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Улаанбаатарын их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тухайн байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.



Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 19-нөөс 2018 оны 3 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 14-нд эцэслэн баталгаажуулж, тус сургуулийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Бодьтусгал-аудит ХХК-ийн аудитор З.Мягмарсүрэн, аудитор Г.Юмчмаа, туслах аудитор Г.Дашмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Улаанбаатарын их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Бодьтусгал-Аудит ХХК-д хуулиар тогтоосон хугацааг 4 хоногоор хоцроож 1/070 албан тоотоор хүргүүлсэн байна. Бидэнд ирүүлсэн санхүүгийн тайлан нь үндсэн хөрөнгийн элэгдлийг 35348,5 мянган төгрөг дутуу тооцоолсон байсныг аудит хийх хугацаанд засуулж, тайланг хүлээн авлаа. Санхүүгийн тайланг чанаргүй бэлтгэж, тайлан өгөх хугацааг хоцроож байгаа асуудлыг дахин гаргуулахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэх нь зүйтэй гэж аудитын багийн зүгээс үзэж байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улаанбаатарын их сургуулийн эрхэм зорилгыг эрдэмтэн багш нарын нөөц бололцоо, сургалтын материаллаг баазад түшиглэн шинжлэх ухаан үйлдвэрлэл нийгмийн бүхий л салбарт бие даан ажиллах чадвартай, хувь хүний хөгжил, харилцааны өндөр соёлтой мэргэжлийн боловсон хүчнийг өөрийн болон өндөр хөгжилтэй орнуудын жишигт нийцүүлэн бэлтгэх, сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогц бодлого бүхий сургуулийн үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлэх явдал гэж тодорхойлжээ.

Улаанбаатар их сургууль нь төрийн болон орон нутгийн өмчид суурилсан хамтын болон өөрийн удирдлагатай, 1992 онд үүсгэн байгуулагдсан бие даасан хуулийн этгээд байна гэж дүрмэндээ заажээ.

Тус сургуулийн хамт олон дүрэмдээ заасны дагуу улс орны нийгэм эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм цаг үеийн эрэлт хэрэгцээ, нийслэлийн бодлого төлөвлөлтөд зохицуулан бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхэлж, мэргэжлийн болон иргэний өндөр боловсролтой мэргэжилтэн, шинжлэх ухааны залуу боловсон хүчнийг бэлтгэх, тэднийг чадавхижуулахаар ажиллаж байна.

Улаанбаатарын их сургууль санхүүгийн үйл ажиллагаандаа Дээд боловсролын тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгын хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын талаар тавигдсан үндсэн чиглэлүүдийг хангахын тулд доорх зорилтуудын хүрээнд ажиллах эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах стратегиин тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж байна. Үүнд

1. Эрдэм шинжилгээ-инноваци-антрепренёршил

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2. Үр дүнд суурилсан сургалт
3. Хүний хөгжил, нийгмийн үйлчилгээ
4. Хамтын ажиллагаа
5. Стандартад нийцсэн их сургуулийн хотхон

Улаанбаатарын их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг гол шалгуур болголоо.

Аудитаар Улаанбаатарын их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, удирдах зөвлөлөөрөө батлуулсан төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 9 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Улаанбаатарын их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.


Тус сургууль нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Powersoft 4.8” програмаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улаанбаатарын их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Дотоод аудитын ажилтан байгаа боловч санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавиагүй, зөвхөн сургалтын чанартай холбоотой гол асуудлуудад төлөвлөгөө гаргаж ажилласан, нэг ажилтан хүрэлдэнгүй гэсэн тайлбарыг өгч байна.



2.6 Төсөв болон төлбөрт орлогын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тус сургуулийн Удирдах зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01 тоотой эрдэм шинжилгээний төсөл хөтөлбөрт 7,920.0 мянган төгрөг, тогтмол зардлын санхүүжилтэнд 84,695.4 мянган төгрөг, сургалтын төлбөрийн орлого 920,126.0 мянган төгрөг, үйл ажиллагааны бус орлого 294,678.0 мянган төгрөг нийт 1,307,419.4 мянган төгрөг орлого орохоор, цалин хөлс, бараа үйлчилгээ, сургалтын үйлчилгээ, эрдэм шинжилгээ, инновацийн, тогтмол(ашиглалтын) зардал, хөрөнгийн зардлуудад нийтдээ 1,307,419.4 мянган төгрөг зарцуулахаар төсвийг баталсан байна.

Гүйцэтгэлээр 2017 оны тогтмол зардлын 67,000.0 мянган төгрөгийг Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын багцаас шууд санхүүжүүлсэн, үндсэн үйл ажиллагааны орлого 1,165,179.9 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 90,548.8 мянган төгрөгийг оруулж, нийтдээ үндсэн үйл ажиллагаандаа 1,305,538.6 сая төгрөгийн зардал гарган, 17,637.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2,928.1 мянган төгрөгийг дутуу зарцуулсан, дараа оны зардалд шилжүүлж тооцохоор байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Улаанбаатарын их сургууль нь цахим хуудас iom.num.edu.mn/сайтад шилэн дансны цэсийг холбоогүй байна. Монгол Улсын Их Сургуулийн бүрэлдэхүүн сургууль байхдаа тус сургуулийн нэр дээр шилэн дансны мэдээлэл нь ордог байсан. Тайлант онд шилэн дансны мэдээллийг оруулаагүй байна. Энэ нь “Шилэн дансны тухай” хуулийн 6 зүйлийн 6.1-д .Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:

6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;
6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;
6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;
6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор; гэж заасныг хэрэгжүүлээгүй

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Нийгмийн даатгалын шимтгэлийн талаар

Цалин хөлсний тооцооллыг шалгахад дараах алдаатай зүйлс илэрсэн.

Тухайлбал:

- Нийгмийн даатгалын дээд хязгаарыг буруу тооцоолж, 1,431.3 мянган төгрөгийн шимтгэлийн дутуу суутгасан
- Нийт тооцоолсон нийгмийн даатгалын шимтгэл нь олговол зохих цалингаас тооцоолсон дүнгээс 2,580.7 мянган төгрөгөөр дутуу
- Цагийн багш нарт олгосон 13,586.4 мянган төгрөгнөөс нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д “Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгэх орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугцаанд төлөх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх

2.9.2 Дотоод аудитын зохион байгуулалтын талаар

Тус сургуулийн Удирдах зөвлөлөөс баталсан төсөв, түүний гүйцэтгэл мөн зарим эрдэм шинжилгээний ажлын явцад тавьсан хяналтыг хангалтгүй зохион байгуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдах зөвлөл тодорхойлно” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;


2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүнг өмнөх онуудад дутуу байгуулсан байна. Тайлант онд 27,328.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авах зөвшөөрлийг Удирдах зөвлөлийн 2017 оны 01; 03 тоот тогтоолоор тус тус шийдүүлсэн. Гэвч энэхүү үндсэн хөрөнгүүдийг худалдан авах талаар Төрийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрөл аваагүй байна.

Эрдэм шинжилгээний ажлын гэрээ байгуулах эрхийг захиралд олгох талаар байгууллагын дүрэм болон бусад эрх зүйн баримт бичигт тодорхой зүйл байхгүй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Улаанбаатарын их сургуулийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар сургалтын төлбөрийн орлогод тавьж байгаа хяналт, эрдэм шинжилгээний зардлын гүйцэтгэлийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.



2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Улаанбаатарын их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 4012,0 мянган төгрөгийн зөрчил илэрснээр холбогдох хуулийн зүйл, заалтыг барьж ажиллах зөвлөмж өгөгдсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Улаанбаатарын их сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “И.Эс.Эс.Эс- Аудит” ХХК аудит хийж, зөрчилгүй дүгнэлт өгсөн байна. Тус аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, дотоод хяналтын ажилтан нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлох бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгийн дүнг сонгов.

Улаанбаатарын их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгийн дүн 2,846,696.0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувиар буюу 28,467.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Улаанбаатарын их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улаанбаатарын их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

“Бодьтусгал-Аудит” ХХК аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Улаанбаатарын их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Ажиглалт

Цалингийн тооцооллыг шалгах явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Арван ажилтны нийгмийн даатгалын дээд хязгаарыг буруу тооцоолж 1,431.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу суутгасан

2. Нийт тооцоолсон нийгмийн даатгалын шимтгэл нь олговол зохих цалингаас тооцоолсон дүнгээс 2,580.7 мянган төгрөгөөр дутуу

3. Цагийн багш нарт 13,586.4 мянган төгрөгийн хөлс тооцоолж олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутгалгүй зөвхөн ХАОАТ суутган олгосон байна. Энэ нь нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д “Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан , түүнтэй адилтгэх орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугцаанд төлөх” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

- Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх;
- Цалин хөлсийг буруу тооцоолж, өр, авлагын тооцоо үүсгэх;

Зөвлөмж

- Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн үнэн зөв тодорхойлон, төлөх
- Цалин хөлсний програмын тооцооллын алдааг засах
- ХАОАТ-ын зөрүүг хүн нэг бүрээр хийж, татварын тайлангийн зөрүүг залруулах

Үйлчлүүлэгчийн хариу

Ажиглалт

1. Удирдах зөвлөлийн баталсан төсөв, гүйцэтгэл (дансны төлөвлөгөө) –ийн үзүүлэлтүүд хоорондоо зөрүүтэй бөгөөд зэрэгцүүлж дүгнэхэд хүндрэлтэй
2. Төслийн удирдагч профессор Д.Эрдэнэбаатарын эрдэм шинжилгээний гэрээт ажлын явцад тавьсан хяналт сул, ажлын гүйцэтгэлийн баримтууд дутуу байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

- Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх;
- Төсөвлөсөн хөрөнгийг зориулалтаар зарцуулахгүй байх
- Ашиглалт гаргах

Зөвлөмж

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;
- Төсөв болон гүйцэтгэл (нягтлан бодох бүртгэлийн дансны төлөвлөгөө)-ийг нэг үзүүлэлттэй болгох;
- Эрдэм шинжилгээ, гэрээт ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, баримтын бүрдлийг хангаж ажиллах; Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 5 ны өдрийн дотор Үндэсний аудитын газар хүргүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬ


4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

№	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	478,932,033.10	371,399,584.07
2	Кассанд байгаа бэлэн мөнгө	0	0
3	Жижиг мөнгөн сан	0	0
4	Банкинд байгаа бэлэн мөнгө- Төгрөг	478,932,033.10	371,399,584.07
8	АВЛАГА	128,420,215.54	158,880,365.54
9	Төлбөртэй үйлчилгээний авлага	128,370,733.00	158,830,883.00
10	Бусад авлага	49,482.54	49,482.54
12	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	0	271,072,810.32
13	Урьдчилгаа тооцоо	0	271,072,810.32
15	БАРАА МАТЕРИАЛ	10,600,025.00	9,838,875.00
19	Хангамжийн материал	10,600,025.00	9,838,875.00
23	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	617,952,273.64	811,191,634.93
27	Барилга, байгууламж	2,767,740,830.00	2,816,985,549.00
28	Хуримтлагдсан элэгдэл	-759,532,816.73	-828,726,337.49
31	Машин тоног төхөөрөмж	456,431,155.00	464,563,755.00
32	Хуримтлагдсан элэгдэл	-384,800,414.50	-391,897,814.61
33	Тавилга эд хогшил	328,986,057.98	347,283,756.98
34	Хуримтлагдсан элэгдэл	-283,823,427.06	-291,599,818.33
37	Номын фонд	113,240,602.00	114,138,602.00
41	Бусад үндсэн хөрөнгө	14,000,000.00	14,000,000.00
42	Хуримтлагдсан элэгдэл	-1,540,000.60	-1,540,000.60
45	Программ хангамж	1,670,000.00	1,670,000.00
46	Хуримтлагдсан элэгдэл	-1,670,000.00	-1,670,000.00
49	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,250,701,985.00	2,243,207,692.00
50	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,868,654,259.00	3,054,399,327.00
62	Урьдчилгаа – Төсвийн татаас	0	243,051,552.00
63	Бусад урьдчилж орсон орлого	249,478,932.50	174,535,189.30
64	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	249,478,932.50	417,586,741.30
68	ЭЗНИЙ ӨМЧ	2,004,868,431.00	2,004,868,431.00
69	Засгийн газрын хувь оролцоо	2,004,868,431.00	2,004,868,431.00
70	Хуримтлагдсан үр дүн	-46,393,455.77	-28,756,196.41
71	Өмнөх үеийн үр дүн	-46,393,455.77	-46,393,455.77




72	Тайлант үеийн үр дүн	0	17,637,259.35
73	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	660,700,351.00	660,700,351.00
74	ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН	2,619,175,326.23	2,636,812,586.58
75	ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН	2,868,654,259.73	3,054,399,327.88

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
2	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,741,299.00	67,447,100.00
3	Улсын төсвөөс	10,741,299.00	67,447,100.00
4	Урсгал	10,741,299.00	67,447,100.00
14	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	1,348,259,068.00	1,255,728,776.00
16	Төсөвт байгууллагын төлбөртэй үйлчилгээний орлого	1,348,259,068.00	1,255,728,776.00
17	Үндсэн үйлажиллагааны орлого	1,143,330,490.00	1,165,179,920.00
18	Үндсэн бус ажил үйлчилгээний орлого	204,928,578.00	90,548,856.03
20	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,359,000,367.00	1,323,175,876.00
22	АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	815,247,085.00	798,132,958.11
23	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	736,026,653.00	721,588,752.09
24	Цалин	736,026,653.00	721,588,752.09
26	Нийгмийн хамгааллын шимтгэл	79,220,431.00	76,544,206.02
27	НДШ-ийн зардал	79,220,431.00	76,544,206.02
31	Гэрэл цахилгааны зардал	19,820,335.00	15,275,457.00
32	Түлш халаалтын зардал	29,881,191.00	34,499,729.90
33	Цэвэр, бохирусны зардал	14,984,292.00	14,743,832.82
38	Бичиг хэргийн зардал	1,532,130.00	1,606,570.00
40	Шуудан холбооны зардал	9,108,229.00	8,671,517.90
43	Ном, хэвлэлийн зардал	3,379,405.00	4,961,991.00
44	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	34,350,131.00	44,700,600.00
47	Жижиг эд хогшил худалдан авах зардал	2,958,293.00	3,725,400.00
48	Зөөлөн эдлэл, нормын хувцасны зардал	240,000.00	0
49	Төлбөр, хураамж, татварууд	9,114,000.00	10,042,000.00
51	Банкны үйлчилгээний хураамж	156,689.00	560,973.58
54	Урсгал засварын зардал	18,131,829.00	49,710,100.00
55	Биеийн тамрын уралдаан тэмцээний зардал	220,000.00	0
56	Гадаадын мэргэжилтний зардал	4,350,598.00	9,813,600.00
57	Гадаадын арга хэмжээний зардал	5,906,815.00	10,470,600.00
58	Шагнал урамшууллын зардал	630,000.00	1,755,000.00
59	Оюутны холбооны зардал	5,473,720.00	13,623,383.00
60	Бусад зардал	164,122,923.00	192,555,971.23
62	Байрны түрээсийн зардал	7,621,700.00	0



64	Элэгдлийн зардал	14,319,943.00	84,067,312.14
65	Хөтөлбөр арга хэмжээний зардал	2,532,500.00	5,421,620.00
67	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	1,200,000.00
68	Бусад зардал	500,000.00	0
71	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,166,081,813.00	1,305,538,617.00
72	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	192,918,554.00	17,637,259.35
85	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	192,918,554.00	17,637,259.35

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийнгазрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр ашиг	ЗГ-ын хувь оролцооны нийт дүн
2015 оны 12-р сарын 31 ны үлдэгдэл	2,004,868,431.00	660,700,351.00	-46,393,455.77	2,619,175,326.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгд	0	0	0	0
НББүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Тайлант үеийн цэвэр ашиг	0	0	0	0
2016 оны 12-р сарын 31 ны үлдэгдэл	2,004,868,431.00	660,700,351.00	-46,393,455.77	2,619,175,326.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгд	0	0	0	0
НББүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
Тайлант үеийн цэвэр ашиг	0	0	17,637,259.35	17,637,259.35
2017 оны 12-р сарын 31 ны үлдэгдэл	2,004,868,431.00	660,700,351.00	-28,756,196.42	2,636,812,586.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО		
3	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,111,500.00	
8	Бусад төсөвт байгууллагаас / үндэсний тэтгэлэг, замын зардал /	2,111,500.00	
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	1,337,480,226.00	1,492,384,740.98
14	Төсөвт байгууллагын төлбөртэй үйлчилгээний орлого	988,523,210.00	974,757,594.80
15	Торгууль, төлбөрийн орлого	348,957,016.00	517,627,146.18
16	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,339,591,726.00	1,492,384,740.98
17	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА		
18	АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	831,887,363.00	805,343,572.26
19	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	678,839,441.00	655,606,108.62
20	Цалин	678,839,441.00	655,606,108.62
23	НДШ-ийн зардал	153,047,922.00	149,737,463.64
24	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377,765,312.00	766,045,317.75
25	Нийтлэг чанартай зардал	136,611,032.00	223,699,583.20
26	Бичиг хэргийн зардал	1,132,130.00	1,574,220.00
27	Гэрэл цахилгааны зардал	19,820,335.00	15,275,457.00
28	Түлш, халаалтын зардал	29,881,192.00	34,560,229.90
29	Цэвэр, бохирусны зардал	14,984,293.00	14,743,832.82
30	Байрны түрээсийн зардал		5,899,200.00
32	Шуудан холбооны зардал	9,108,229.00	8,591,517.90
37	Ном, хэвлэлийн зардал	3,114,605.00	4,814,597.00
38	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,146,420.00	599,250.00



39	Урсгал засварын зардал	18,340,829.00	98,244,819.00
40	Сургалт семинарын зардал		200,000.00
41	Төлбөр, хураамж	8,479,000.00	9,002,000.00
43	Банкны үйлчилгээний хураамж	156,689.00	210,973.58
44	Маягт хэвлүүлэх зардал	1,030,000.00	147,400.00
46	Бусад зардал	20,769,411.00	29,836,092.00
47	Тусгай материал, үйлчилгээний зардал	241,154,279.00	542,345,734.55
48	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	35,426,216.00	68,761,450.00
49	Эрдэм шинжилгээний ажлын зардал	186,748,595.94	438,399,281.55
51	Зөөлө нэдлэл, нормын хувцас худалдан авах зардал	240,000.00	
52	Оюутны үйлчилгээний зардал	5,473,720.00	13,623,383.00
55	Гадаадын зочны зардал	11,323,247.00	14,385,000.00
56	Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	1,312,500.	
73	Салбарын төвлөрсөн арга хэмжээ	630,000.00	7,176,620.00
78	ТАТААС, САНХҮҮЖИЛТ	3,611,500.00	1,200,000.00
85	Оюутны тэтгэлэг	2,111,500.00	
86	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	1,200,000.00
89	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	1,213,264,175.00	1,572,588,890.01
90	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	126,327,551.00	-80,204,149.03
97	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	7,002,800.00	27,328,300.00
108	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	7,002,800.00	27,328,300.00
109	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	7,002,800.00	-27,328,300.00
110	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТЭНЦЭЛ	-7,002,800.00	-27,328,300.00
111	САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨ	119,324,751.00	-107,532,449.03
116	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	119,324,751.00	-107,532,449.03
117	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	359,607,282.00	478,932,033.10

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАА ДУНДАЛТ

	үлдэгдэл		
118	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	478,832,033.00	371,399,584.07

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2017.12.31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,695,400.00	64,519,019.00	20,176,381.00	76.2%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,695,400.00	64,519,019.00	20,176,381.00	76.2%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,695,400.00	64,519,019.00	20,176,381.00	76.2%
210301	Гэрэл, цахилгаан	27,937,100.00	15,275,457.00	12,661,643.00	55%
210302	Түлш, халаалт	38,758,300.00	34,499,729.00	4,258,571.00	89%
210303	Цэвэр, бохир ус	18,000,000.00	14,743,833.00	3,256,167.00	82%
310001	Улсын төсвөөс санхүүжих	84,695,400.00	67,447,100.00	17,248,300.00	79.6%

